

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зүүнхангай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/175/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаангом хот 2022 он</p>	<p>Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Ахлах аудитор: А.Нанжидмаа Утас: 70453721, Цахим хаяг: Nanjidmaaa@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
3. Аудитын тайлан	2
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал.....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
4. Аудитын илрүүлэлт.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	17



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

ЗҮҮНХАНГАЙ СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
Л.МЯНГАНБАЯР ТАНАА

2022.02.25 №УВА-2022/175/НА-СНА-ТМЦ
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зүүнхангай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Зүүнхангай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Зүүнхангай сумын Эрүүл мэндийн төв нь төрийн албан хаагчийн мөнгөн урамшуулал болон ковид-19 цар тахалтай холбогдуулан Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 377/А99 дугаар тушаалаар олгосон урамшуулалтай давхардуулан эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэргүйгээр ажилтнуудад 25,200.0 мянган төгрөгийн мөнгөн тэтгэмж олгосон, эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр өөрөө өөртөө шийдвэр гарган 3,000.0 мянган төгрөгийн тэтгэмж авсан зөрчлүүд нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.-д “Албан тушаалтан хандив, санхүүгийн туслалцааг авахын өмнө өөрийн удирдлага, эсхүл эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан байна.”, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.2 дахь хэсэгт “Албаны эрх мэдлээ хэтрүүлэх;” Төсвийн тухай хуулийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3.12-т “Эрүүл мэндийн байгууллагын даргын ажлын үр дүнг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар болон тухайн албан тушаалтныг томилсон эрх бүхий албан тушаалтан дүгнэж, шийдвэр гаргана” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, Эрүүл мэндийн Сайдын А/496, аймгийн Эрүүл мэндийн газрын А/81 тушаалуудтай нийцэхгүй, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

0200200561

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>34,181,696.14</u>	<u>158,434,538.33</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	3,999,094.00
31221	Төрийн сангийн харилцах	00.00	3,999,094.00
33	АВЛАГА	00.00	98,538,576.89
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	331,076.89
33200	Төлбөргүй үйлчилгээний авлага	00.00	98,207,500.00
35	БАРАА МАТЕРИАЛ	34,181,696.14	55,896,867.44
351	Түүхий эд материал	1,558,451.00	11,073,641.00
35110	Тусгай зориулалттай материал	567,000.00	8,439,900.00
35130	Эм боох материал	991,451.00	2,633,741.00
35400	Хангамжийн материал	32,623,245.14	44,823,226.44
35410	Бичиг хэргийн материал	381,234.00	1,933,984.00
35420	Аж ахуйн материал	16,724,825.00	25,096,325.00
35440	Түлш, шатах тослох материал		
35460	Хүнсний материал	12,840,724.46	15,116,455.76
35470	Бусад хангамжийн материал		
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>391,295,568.40</u>	<u>439,892,500.84</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	391,295,568.40	439,892,500.84
39200	Биет хөрөнгө	380,743,568.40	429,340,500.84
39201	Барилга, байгууламж, орон сууц	294,453,232.05	294,453,232.05
39202	Хуримтлагдсан элэгдэл	-16,687,285.68	-25,030,928.52
39203	Авто-тээврийн хэрэгсэл	65,668,826.00	109,019,634.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-34,510,645.21	-40,020,192.23
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	120,215,133.00	124,583,842.56
39206	Хуримтлагдсан элэгдэл	-55,234,886.65	-52,159,183.78
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20,451,040.00	27,289,300.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-14,898,100.20	-12,371,369.60
39214	Бусад хөрөнгө	5,577,347.00	5,927,196.53
39215	Хуримтлагдсан элэгдэл	-4,396,091.91	-2,456,030.17
39300	Биет бус хөрөнгө	10,552,000.00	10,552,000.00
39301	Программ	440,000.00	440,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-440,000.00	-440,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	10,552,000.00	10,552,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>425,477,264.54</u>	<u>598,327,039.17</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>10,602,604.03</u>	<u>7,704,472.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	10,602,604.03	7,704,472.00
413	Өглөг	10,602,604.03	7,704,472.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,520,876.03	00.00
4136	Бусад өглөг	9,081,728.00	7,704,472.00

41361	Байгууллагад төлөх өглөг	9,081,728.00	7,704,472.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	414,874,660.51	590,622,567.17
51	Засгийн газрын хувь оролцоо	414,874,660.51	590,622,567.17
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	198,875,568.62	198,875,568.62
51200	Хуримтлагдсан үр дүн	91,237,908.54	268,282,289.20
51210	Өмнөх үеийн үр дүн	91,237,908.54	92,534,382.54
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	175,747,906.66
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	124,761,183.35	123,464,709.35
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	425,477,264.54	598,327,039.17

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	416,729,186.00	750,874,210.09
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	387,361,045.00	519,513,910.09
120	Нийтлэг татварын бус орлого	21,265,765.00	93,140,350.09
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	21,265,765.00	93,140,350.09
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	21,265,765.00	93,140,350.09
122	Тусламжийн орлого	22,508,580.00	19,049,260.00
122001	Хандив тусламж /дотоод/	22,508,580.00	19,049,260.00
123	Улсын төвлөрсөн төсвөөс	343,586,700.00	407,324,300.00
123001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	343,586,700.00	407,324,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	29,368,141.00	231,360,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,054,400.00	97,854,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	7,350,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,054,400.00	90,504,000.00
1330	Төсвийн захирагчдаас	19,313,741.00	35,298,800.00
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	19,313,741.00	35,298,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	00.00	98,207,500.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	98,207,500.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	438,704,564.46	573,309,919.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	438,704,564.46	573,309,919.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	435,621,985.46	497,964,889.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	272,559,165.00	306,163,846.16
210101	Үндсэн цалин	244,244,885.00	274,530,003.16
210102	Нэмэгдэл	5,808,000.00	5,730,000.00
210104	Урамшуулал	17,466,280.00	21,030,807.00
210105	Гэрээт ажлын хөлс	5,040,000.00	4,873,036.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,826,883.06	41,158,941.92
210201	Тэтгэврийн даатгал	23,926,883.06	29,266,940.47
210202	Тэтгэмжийн даатгал	2,725,000.00	3,797,736.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,180,420.00	2,164,712.59
210204	Ажилгүйдлийн даатгал	544,580.00	538,913.84
210205	Эрүүл мэндийн даатгал	5,450,000.00	5,390,638.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,263,624.00	17,953,769.94

Зүүнхангай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210301	Гэрэл, цахилгаан	1,731,757.00	1,583,992.34
210302	Түлш, халаалт	13,481,867.00	16,049,777.60
210303	Цэвэр, бохир ус	50,000.00	320,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,262,794.00	35,840,550.00
210401	Бичиг хэрэг	2,516,256.00	2,655,350.00
210402	Тээвэр, шатахуун	25,644,360.00	29,580,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,077,978.00	785,000.00
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	28,800.00	283,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	995,400.00	2,537,000.00
2105	Нормативт зардал	34,183,922.80	53,581,922.70
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	31,436,328.00	48,186,254.00
210502	Хоол, хүнс	2,747,594.80	5,395,668.70
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,149,400.00	2,065,000.00
210601	Багаж хэрэгсэл	10,000,000.00	00.00
210604	Урсгал засвар	2,149,400.00	2,065,000.00
2107	Томилолт, зочны зардал	473,500.00	1,150,000.00
210702	Дотоод албан томилолт	473,500.00	1,150,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,841,060.00	1,676,925.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	950,000.00	300,000.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	120,000.00	360,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	108,900.00	165,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	103,760.00	142,025.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	66,000.00	99,000.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	413,500.00	532,000.00
210807	Газрын төлбөр		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,061,636.60	38,373,934.05
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,269,960.00	217,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	32,791,676.60	38,156,434.05
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,082,579.00	75,345,030.06
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	60,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	60,000,000.00
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,082,579.00	15,345,030.06
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	00.00	-1,816,383.60
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-21,975,378.46	175,747,906.66

2.3 АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	198,875,568.62	124,761,183.35	113,325,656.97	436,962,408.94
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт				
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
7	Өмчид гарсан өөрчлөлт				
8	Зарласан ногдол ашиг				
9	Тайлант үеийн үр дүн			-22,087,748.43	-22,087,748.43
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	198,875,568.62	124,761,183.35	91,237,908.54	414,874,660.51
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	198,875,568.62	124,761,183.35	91,237,908.54	414,874,660.51
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	1,296,474.00	1,296,474.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	198,875,568.62	124,761,183.35	92,534,382.54	416,171,134.51
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	00.00	-1,296,474.00	00.00	-1,296,474.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
17	Өмчид гарсан өөрчлөлт				
18	Зарласан ногдол ашиг				
19	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	175,747,906.66	175,747,906.66
20	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	198,875,568.62	123,464,709.35	268,282,289.20	590,622,567.17

2.4 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	405,463,421.00	559,526,360.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	366,095,280.00	426,373,560.00
122	Тусламжийн орлого	22,508,580.00	19,049,260.00
122001	Хандив тусламж /дотоод/	22,508,580.00	19,049,260.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	343,586,700.00	407,324,300.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	343,586,700.00	407,324,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	39,368,141.00	133,152,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,054,400.00	97,854,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	7,350,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,054,400.00	90,504,000.00
1330	Төсвийн захирагчдаас	19,313,741.00	35,298,800.00
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	19,313,741.00	35,298,800.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	405,463,421.00	555,527,266.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	405,463,421.00	555,527,266.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	402,380,842.00	480,182,235.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	271,699,180.00	308,015,800.00
210101	Үндсэн цалин	243,384,900.00	276,532,454.00
210102	Нэмэгдэл	5,808,000.00	5,730,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,466,280.00	20,982,821.00
210104	Урамшуулал	5,040,000.00	4,770,525.00
210105	Гэрээт ажлын хөлс	34,062,300.00	41,158,941.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,162,300.00	29,266,939.55
210201	Тэтгэврийн даатгал	2,725,000.00	3,797,736.76
210202	Тэтгэмжийн даатгал	2,180,420.00	2,164,712.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	544,580.00	538,913.84
210204	Ажилгүйдлийн даатгал	5,450,000.00	5,390,638.26
210205	Эрүүл мэндийн даатгал	15,263,624.00	17,953,769.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,731,757.00	1,583,992.34
210301	Гэрэл, цахилгаан	13,481,867.00	16,049,777.60
210302	Түлш, халаалт	50,000.00	320,000.00
210303	Цэвэр, бохир ус	405,463,421.00	555,527,266.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,475,678.00	38,652,000.00
210401	Бичиг хэрэг	1,450,000.00	2,180,000.00
210402	Тээвэр, шатахуун	25,315,200.00	29,580,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,310,478.00	1,792,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэдрэгчдийн устгал, ариутгал	1,000,000.00	3,200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,300,000.00	1,800,000.00
2105	Норматив зардал	29,260,500.00	55,711,200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	21,460,500.00	44,833,100.00

Зүүнхангай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210502	Хоол, хүнс	5,300,000.00	7,078,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,500,000.00	3,800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,505,000.00	12,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,005,000.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	6,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	473,500.00	1,150,000.00
210702	Дотоод албан томилолт	473,500.00	1,150,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,841,060.00	1,676,925.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	950,000.00	300,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	120,000.00	360,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	108,900.00	165,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	103,760.00	142,025.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	66,000.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	413,500.00	532,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,800,000.00	3,863,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,800,000.00	3,863,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,082,579.00	75,345,030.06
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	60,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	60,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,082,579.00	15,345,030.06
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,082,579.00	15,345,030.06
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		<u>3,999,094.00</u>
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		3,999,094.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		3,999,094.00

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /					
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	465,794,300.00	442,328,235.94	23,466,064.06	95.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	465,794,300.00	442,328,235.94	23,466,064.06	95.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	465,794,300.00	442,328,235.94	23,466,064.06	95.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	300,795,600.00	294,149,146.00	6,646,454.00	97.8
210101	Үндсэн цалин	262,665,800.00	262,665,800.00	0.00	100.0
210103	Унаа , болон бусад нөхөн олговор	5,808,000.00	5,730,000.00	78,000.00	98.7
210104	Урамшуулал	27,281,800.00	20,982,821.00	6,298,979.00	76.9
210105	Гэрээт ажлын хөлс	5,040,000.00	4,770,525.00	269,475.00	94.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,607,400.00	39,302,295.00	1,305,105.00	96.8
210201	Тэтгэврийн даатгал	28,575,600.00	28,502,189.55	73,410.45	99.7
210202	Тэтгэмжийн даатгал	3,008,000.00	2,705,840.76	302,159.24	90.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,406,300.00	2,164,712.59	241,587.41	90.0
210204	Ажилгүйдлийн даатгал	601,600.00	538,913.84	62,686.16	89.6
210205	Эрүүл мэндийн даатгал	6,015,900.00	5,390,638.26	625,261.74	89.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,298,800.00	17,953,769.94	15,345,030.06	53.9
210301	Гэрэл, цахилгаан	4,200,000.00	1,583,992.34	2,616,007.66	37.7
210302	Түлш, халаалт	28,778,800.00	16,049,777.60	12,729,022.40	55.8
210303	Цэвэр, бохир ус	320,000.00	320,000.00	0.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	37,702,000.00	37,702,000.00	0.00	100.0
210401	Бичиг хэрэг	1,800,000.00	1,800,000.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	29,010,000.00	29,010,000.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,792,000.00	1,792,000.00	0.00	100.0
210404	Ном, хэвлэл	100,000.00	100,000.00	0.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах хортон мэдрэгчдийн устгал ариутгал	3,200,000.00	3,200,000.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,800,000.00	1,800,000.00	0.00	100.0
2105	Нормативт зардал	39,030,500.00	39,030,500.00	0.00	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	28,730,500.00	28,730,500.00	0.00	100.0
210502	Хоол, хүнс	6,500,000.00	6,500,000.00	0.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,800,000.00	3,800,000.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,500,000.00	7,500,000.00	0.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	5,000,000.00	0.00	100.0

Зүүнхангай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	500,000.00	500,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	1,150,000.00	1,150,000.00	0.00	100.0
210702	Дотоод албан томилолт	1,150,000.00	1,150,000.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,846,400.00	1,676,925.00	169,475.00	90.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300,000.00	300,000.00	0.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	360,000.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	165,000.00	165,000.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	311,500.00	142,025.00	169,475.00	45.6
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	99,000.00	99,000.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	532,000.00	532,000.00	0.00	100.0
210807	Газрын төлбөр	78,900.00	78,900.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3863600.00	3863600.00	0.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,863,600.00	3,863,600.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ				
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	465,794,300.00	461,672,360.00	4,121,940.00	99.1
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	407,324,300.00	407,324,300.00	0.00	100.0
310001	Улсын төсвөөс санхүүжих	407,324,300.00	407,324,300.00	0.00	100.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	35,298,800.00	35,298,800.00		
	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	35,298,800.00	35,298,800.00		
	Орон нутгийн төсвөөс	35,298,800.00	35,298,800.00		
	НД-ЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	23,171,200.00	19,049,260.00	4,121,940.00	82.2
	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	23,171,200.00	19,049,260.00	4,121,940.00	82.2
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		3,999,094.00	-3,999,094.00	

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		97,854,000.00	97,854,000.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ		97,854,000.00	97,854,000.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		37,854,000.00	37,854,000.00	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		13,866,654.00	13,866,654.00	
210101	Үндсэн цалин		13,866,654.00	13,866,654.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,856,646.00	1,856,646.00	
210201	Тэтгэврийн даатгал		764,750.00	764,750.00	
210202	Тэтгэмжийн даатгал		1,091,896.00	1,091,896.00	
2104	Хангамж, бараа материалын зардал		950,000.00	950,000.00	
210401	Бичиг хэрэг		380,000.00	380,000.00	
210402	Тээвэр, шатахуун		570,000.00	570,000.00	
2105	Норматив зардал		16,680,700.00	16,680,700.00	
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		16,102,600.00	16,102,600.00	
210502	Хоол, хүнс		578,100.00	578,100.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		4,500,000.00	4,500,000.00	
210604	Урсгал засвар		4,500,000.00	4,500,000.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		60,000,000.00	60,000,000.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг		60,000,000.00	60,000,000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		60,000,000.00	60,000,000.00	
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		97,854,000.00	97,854,000.00	
31	Нэмэлт санхүүжилтийн орлого		97,854,000.00	97,854,000.00	
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		7,350,000.00	7,350,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		32,798,800.00	32,798,800.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		57,705,200.00	57,705,200.00	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Зүүнхангай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Нанжидмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Зүүнхангай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Зүүнхангай сумын Эрүүл мэндийн төв нь Хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан төрөөс өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон үндсэн мэргэшлийн зарим нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг иргэн, гэр бүл, аж ахуйн нэгжийн оролцоотойгоор харьяалах нутаг дэвсгэрт байгаа хүн бүрд нь нутаг дэвсгэрийн харьяалал харгалзахгүйгээр үзүүлэх үйл ажиллагааг явуулдаг байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас Зүүнхангай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зүүнхангай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 8,775.0 мянган төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 573,309.9 мянган төгрөгийн 2 хувь буюу 11,466.0 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 9,174.0 мянган төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Зүүнхангай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 172,849.7 мянган төгрөгөөр буюу 28.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	3,999.0	3,999.0
Авлага	0.00	98,538.8	98,538.8
Урьдчилгаа			
Бараа материал	34,181.7	55,896.8	21,715.1
Үндсэн хөрөнгө	391,295.5	439,892.5	48,593.9
Нийт хөрөнгө	425,477.2	598,327.0	172,849.7
Өр төлбөр	10,602.6	7,704.4	-2,898.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	414,874.6	590,622.5	175,747.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	425,477.2	598,327.0	172,849.7

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 3,999.0 мянган төгрөг болж 3,999.0 мянган төгрөгөөр өссөн нь үлдэгдэл төвлөрүүлээгүйгээс шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 98,896.8 мянган төгрөг болж 98,896.8 мянган төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилт дутуу ирснээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 55,896.8 мянган төгрөг болж 21,715.1 мянган төгрөгөөр өссөн нь Ковид-19 цар тахлаас шалтгаалан аж ахуйн материал, эм боох материал нэмэгдсэнээс шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Оны эцэст бараа материалын нөөц үүсгэсэн нь ирэх онд Ковид-19 цар тахалд зарцуулахаар байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 439,892.5 мянган төгрөг болж 48,593.9 мянган төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгийн дансанд урсгал төсвийн худалдан авалтаар 9,675.0 мянга, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 78,894.7 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгөөс акталж устгасан 33,662.1 мянган төгрөгийн хөрөнгө хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 590,622.5 мянган төгрөг болж 175,747.9 мянган төгрөгөөр өссөн нь шинээр нэмэгдсэн үндсэн хөрөнгө, тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 334,145.0 мянган төгрөгөөр буюу 80.2 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээж авсан орлого, нэмэлт санхүүжилтийн орлого, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих орлого байна. Энэ нь Ковид-19 цар тахалтай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 134,605.3 мянган төгрөгөөр буюу 30.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан цалин, НДШ, байр ашиглалттай холбоотой зардал, хангамжийн бараа материалын зардал, норматив зардал, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл зэрэг зардлууд байна. Энэ нь ковид-19 цар тахалтай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 682,610.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 682,610.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 218,819.3 мянган төгрөгөөр бууруулж 464,430.7 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь өмнөх оны гүйцэтгэлээр баталдагтай холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 465,794.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 407,324.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 35,298.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 23,171.2 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 407,324.3 мянга, орон нутгийн төсвөөс 35,298.8 мянга, эрүүл мэндийн даатгалын сангаас 19,049.2 мянга, нийт 461,672.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 442,328.2 мянган төгрөгийг зарцуулсан байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 3,999.0 мянган төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 442,328.2 мянган төгрөг буюу 95.0 хувьтай байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагчаас 32,798.8 мянга үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 57,705.2 мянга, иргэдээс ирсэн хандив 7,350.0 мянга, нийт 97,854.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс урамшууллын зардалд 13,866.6 мянга, НДШ зардалд 1,856.6 мянга, хангамж, бараа материалын зардалд 950.0 мянга, эм боох материалын зардалд 16,680.7 мянга, хоол хүнсний зардалд 578.1 мянга, урсгал засварын зардалд 4,500.0 мянга, нэг удаагийн тэтгэмжийн зардалд 60,000.0 мянга, нийт 97,854.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Зүүнхангай сумын Эрүүл мэндийн төвийн хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 хугацаандаа оруулсан 149 мэдээлэл байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Зүүнхангай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайланд Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих төлбөрт үйлчилгээний орлогын 98,207.5 мянган төгрөгийн авлага тусгагдсан байна. 2022 оны 1 дүгээр сард санхүүжилтийг олгосон байна. Дараагийн аудитаар тухайн авлагын зарцуулалтыг нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 60,401.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 32,201.5 мянган төгрөгийн залруулга, 3,000.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх албан шаардлага, 25,200.0 мянган төгрөгийн зөвлөмж өглөө.

Нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

4.1. Нэмэлт санхүүжилтийн 32,201.5 мянган төгрөгийн орлогыг дутуу тайлагнасныг залрууллаа.

4.3. Албан шаардлага

Зүүнхангай сумын Эрүүл мэндийн төвийн дарга нь Эрүүл мэндийн сайдын А/496 дугаар тушаалаар олгосон төрийн албан хаагчийн мөнгөн урамшуулал болон Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 377/А99 дугаар тушаалаар баталсан цалин хөлс, урамшуулалтай давхардуулан эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэргүйгээр өөрөө өөртөө шийдвэр гарган 3,000.0 мянган төгрөгийн мөнгөн тэтгэмж авсан зөрчилд албан шаардлага өглөө.

4.4. Мөнгөн урамшуулалтай холбоотой асуудал

1. Илрүүлэлт

Зүүнхангай сумын Эрүүл мэндийн төв нь төрийн албан хаагчийн мөнгөн урамшуулал болон ковид-19 цар тахалтай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/496 дугаар тушаалаар олгосон мөнгөн тэтгэмжтэй давхардуулан эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэргүйгээр ажилтнуудад 25,200.0 мянган төгрөгийн мөнгөн тэтгэмж олгосон байна.

1.1. Өгсөн зөвлөмж:

Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 64/А/268 дугаар тушаалын 3.7 “Энэхүү журмын 3.1-3.5-д заасан санхүүжилтэд эмч, эмнэлгийн ажилтны цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, эм, урвалж бодисын зэрэг шууд зардал болон холбогдох шууд бус зардал багтана” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Зүүнхангай сумын Эрүүл мэндийн төв	3	60,401.5	1	32,201.5			1	3,000.0	1	25,200.0

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР



/М.БАГСУУРЬ/

/М.БАТ-АМГАЛАН/

/А.НАНЖИДМАА/

2022 оны 02 сарын 25-ны өдөр



УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 01/25/А 2070416
УВА-2022/175/НА-СГА АМС

Улаангом

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Зүүнхангай сумын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Зүүнхангай сумын Эрүүл мэндийн төвийн дарга нь өөрөө өөртөө шийдвэр гарган 3,000.0 мянган төгрөгийн мөнгөн тэтгэмж авсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтад "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.-д "Албан тушаалтан хандив, санхүүгийн туслалцааг авахын өмнө өөрийн удирдлага, эсхүл эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан байна", Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.2 дахь хэсэгт "Албаны эрх мэдлээ хэтрүүлэх;" Төсвийн тухай хуулийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоол "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 3.12-т "Эрүүл мэндийн байгууллагын даргын ажлын үр дүнг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар болон тухайн албан тушаалтныг томилсон эрх бүхий албан тушаалтан дүгнэж, шийдвэр гаргана", Эрүүл мэндийн Сайдын А/496, Эрүүл мэндийн газрын А/81 тушаалуудыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалтад "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6 дахь заалтад "Төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэргүйгээр мөнгөн тэтгэмж олгосон зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2022 оны 4 дугаар сарын 30-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газар² т ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зүүнхангай сумын Эрүүл мэндийн төвийн дарга Л.Мянганбаяр, нягтлан бодогч К.Бибиш нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.НАНЖИДМАА

М.БАТСУУРЬ

